

**ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ  
УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН  
НЭГДСЭН ДҮН  
*/хураангуй/***

## **АГУУЛГА**

1. ХҮН АМ .....	4
2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА .....	5
3. ШАШИН.....	6
4. ХҮН АМЫН СУУРЬШИЛ .....	6
5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН.....	7
6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ .....	7
7. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ.....	8
8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ .....	8
9. ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ.....	10
10. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ.....	11
11. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭД.....	13
12. СУУЦНЫ НӨХЦӨЛ.....	14

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

ХҮСНЭГТ 1. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХАРЬЯАТ ИРГЭДИЙН ТОО, ҮНДЭС, УГСАА, ХУВИАР 2020 ОН .....	5
ХҮСНЭГТ 2. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН .....	14

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР .....	4
ЗУРАГ 2. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО .....	5
ЗУРАГ 3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН.....	6
ЗУРАГ 4. ХҮН АМЫН СУУРЬШЛЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ, 2020 ОН .....	6
ЗУРАГ 5. ШИЛЖИЖ ИРСЭН, ЯВСАН ХҮНИЙ ТОО, ХУГАЦАА 2020 ОН.....	7
ЗУРАГ 6. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМ .....	7
ЗУРАГ 7. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН .....	8
ЗУРАГ 8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН .....	9
ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, СУМДЫН НИЙТ ХҮН АМД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН .....	9
ЗУРАГ 10. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010, 2020 ОН .....	10
ЗУРАГ 11. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ГАР УТАС ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН .....	10
ЗУРАГ 12. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН .....	11
ЗУРАГ 13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН .....	12
ЗУРАГ 14. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН ХОТ, ХӨДӨӨГӨӨР .....	12
ЗУРАГ 15. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО .....	13
ЗУРАГ 16. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН СУМААР, 2020 ОН.....	13
ЗУРАГ 17. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ХУВИАР, 2020 ОН .....	14
ЗУРАГ 18. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, 2020 ОН .....	15
ЗУРАГ 19. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН .....	15

## 1. ХҮН АМ

Говьсүмбэр аймгийн хүн амын тоо 2020 оны тооллогоор 17928 болсон байна. Хүн амаас гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа 512 иргэн байгаа нь хүн амын 2.9 хувийг эзэлж байна. Мөн тус аймгийн нутаг дэвсгэрт 6, түүнээс дээш сарын хугацаагаар гадаадын харьяат 29 иргэн оршин сууж байна.

Говьсүмбэр аймгийн хүн ам 2010 оны тооллогоор 13239 байсан бол 2010-2020 оны хоорондох 10 жилийн хугацаанд 4689 хүнээр буюу 35.4 хувиар өссөн байна. Хүн амын 9027 буюу 50.4 хувь нь эрэгтэйчүүд, 8901 буюу 49.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

Говьсүмбэр аймгийн хүн ам нь насны хувьд залуу хэвээрээ байгаа бөгөөд 0-14 насны хүүхэд 6072 буюу 33.9 хувь, 15-64 насны хүн ам 11203 буюу 62.5 хувь, 65, түүнээс дээш насны хүн ам 653 буюу 3.6 хувийг тус тус эзэлж байна.

2010 онд хүйсийн харьцаа 106.1 байсан бол /100 эмэгтэйд ногдох эрэгтэй/ 2020 онд 101.4 болж буурчээ.

Хүн амыг насны хувьд таллан хувааж буй голч нас нь 2010 оны тооллогоор 25.7 байсан бол 2020 оны тооллогоор 27.7 болсон байна. Энэ нь хүн амын тэн хагас нь 27.7 - оос доош настай, үлдсэн 50 хувь нь түүнээс дээш насныхан байгааг харуулж байгаа юм.


Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцааг хүн ам зүйн ачаалал гэнэ. Манай аймгийн хүн ам зүйн ачаалал 2010 онд 52.4 хувь байсан бол 2020 онд 60.0 хувь болж 2010 оноос 7.6 пунктээр өссөн байна.

ЗУРАГ 1. ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР



Хүн амын жилийн дундаж өсөлт 2000-2010 онд 0.08 хувь байсан бол 2010-2020 онуудад 0.35 болж, хүн ам өссөн байна.

## ЗУРАГ 2. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО



### 2. ХҮН АМЫН ҮНДЭС, УГСАА

Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор Говьсүмбэр аймгийн харьяат иргэдийн үндэс угсааны талаарх мэдээллийг цуглуулахдаа өмнөх тооллогоос дэлгэрэнгүй бүлгээр авсан.

ХҮСНЭГТ 1. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СУУРИН ХҮН АМ, ҮНДЭС, УГСАА, ХҮЙСЭЭР 2010, 2020 ОН

	2010			2020		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Үндэс угсаа-Бүгд	13 081	6 740	6 341	17 445	8 796	8 649
Монгол улсан харьяат Бүгд	13 038	6 703	6 335	17 416	8 771	8 645
Халх	12 438	6 375	6 063	16 595	8 360	8 235
Казах	52	26	26	85	47	38
Дөрвөд	133	70	63	214	111	103
Буриад	40	20	20	52	25	27
Баяд	209	112	97	258	122	136
Дарьганга	21	10	11	62	34	28
Урианхай	21	14	7	14	7	7
Захчин	31	22	9	33	14	19
Дархад	4	1	3	23	10	13
Торгууд	35	22	13	24	15	9
Өөлд	3	3	-	9	3	6
Хотон	14	9	5	9	3	6
Мянгад	7	3	4	11	6	5
Барга	10	5	5	8	5	3
Харчин	1	1	-	3	2	1
Хотгойд	3	2	1	7	3	4
Сартуул	6	2	4	1	1	0
Тува	8	5	3	2	1	1
Бусад гадаад /Монголын харьяат/	-	-	-	6	2	4

Говьсүмбэр аймгийн суурин хүн амын 95.3 хувийг Халхчууд эзэлж, өмнөх тооллогын үеийнхээс 0.1 пунктээр буурсан байна. Баядуудын эзлэх хувь өнгөрсөн 10 гаруй жилд 0.2 пунктээр буурсан хэдий ч хүн амын 1.4 хувийг эзэлж байгаа нь Халхуудын дараа орж байна. Буриад, Хотон, Урианхай, Барга, Сартуулуудын эзлэх хувь буурсан бол Дөрвөд, Баяд, Дарьгангачуудын эзлэх хувь бага зэрэг өссөн байна.


### 3. ШАШИН

15, түүнээс дээш насны хүн амаас “Та шашин шүтдэг үү, шүтдэг бол ямар шашин шүтдэг вэ?” гэсэн асуултад суурин хүн амын 51.8 хувь нь ямар нэг шашин шүтдэггүй, 48.2 хувь нь шашин шүтдэг гэж тоологдлоо.

Шашин шүтлэгтэй хүмүүсийн 90.3 хувь нь Буддын, 6.7 хувь нь Бөөгийн, 2.0 хувь нь Христийн, 0.4 хувь нь Ислам, 0.6 хувь нь Бусад шашинтан байна.

Шашинтангуудын дотор эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдээс илүү олон буюу 57.0 хувь байна. Шашинтан эмэгтэйчүүдийн 89.3 буддын, 6.6 хувь нь бөөгийн, 3.3 христийн шашинтан байна.

ЗУРАГ 3. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ШАШИН ШҮТЛЭГТЭЙ ХҮН АМ, ШАШНЫ ТӨРӨЛ, ХУВИАР, 2020 ОН




### 4. ХҮН АМЫН СУУРЬШИЛ

Хүн амын суурьшлыг хот, хөдөө, бүс нутгаар тодорхойлох нь тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг гүнзгийрүүлэн судалж, бүс нутгийн болон орон нутгийн онцлогт тохирсон бодлого боловсруулах үндэс болно.

Хүн амын суурьшлыг ангилж үзэхэд нийт хүн амын 12704 буюу 72.8 хувь нь Сүмбэр суманд, 1129 буюу 6.5 хувь нь Баянтал суманд, 3612 буюу 20.7 хувь нь Шивээговь суманд оршин сууж байна.

Говьсүмбэр аймгийн хүн амын нягтрал 2010 онд 2.4 байсан бол 2020 онд 3.1 болж 0.8 пунктээр өссөн байна. Хүн амын нягтрал Баянтал суманд 1.2, Сүмбэр суманд 3.4, Шивээговь суманд 4.2 байна.


ЗУРАГ 4. ХҮН АМЫН СУУРЬШЛЫН ЕРӨНХИЙ БАЙДАЛ, 2020 ОН



## 5. ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Төрснөөс хойших аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогч нийт суурин хүн амын 45.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллоготой харьцуулахад оноос 17.2 пунктээр буурсан байна.

ЗУРАГ 5. ШИЛЖИЖ ИРСЭН, ЯВСАН ХҮНИЙ ТОО, ХУГАЦАА 2020 ОН



\* - Хүн амын 10 хувийг уламжлалт аргаар тооллогод хамруулсан дүнгээр тооцов.

Сүүлийн 5 жилийн шилжих хөдөлгөөнд аймаг, нийслэлийн хоорондох шилжилт хөдөлгөөн 18.6 хувийг эзэлж 2010 оны тооллогоос 10.9 пунктээр өссөн байна.

Сүүлийн жилүүдэд нийт шилжилт хөдөлгөөний 67.6 хувийг Улаанбаатар хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн эзэлж байгаа нь хот руу чиглэсэн урсгал эрчимжсэн байна.


Говьсүмбэр аймгийн хүн амын ихэнх нь Улаанбаатар хот болон зэргэлдээ аймгуудаас ялангуяа Дундговь аймгаас шилжин ирж суурьшсан хүмүүс байгаа ба шилжин ирэгчид нь шилжин явагчдаас их байна.

Шилжин ирсэн хүмүүсийн ихэнх нь эрэгтэй хүмүүс байгааг дүгнэхэд уул уурхай, зам тээвэр барилгын салбар түлхүү хөгжиж буйг харуулж байна.

## 6. БОЛОВСРОЛ, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ

Арав, түүнээс дээш настай хүн амд боловсролтой хүн амын эзлэх хувь өмнөх тооллогын үеийнхээс 2.6 пунктээр нэмэгдэж 95.5 хувь болсон байна.

ЗУРАГ 6. АРАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМ



\* Нийт 10, түүнээс дээш насны хүн амын тоонд Монгол Улсад удаан хугацаагаар амьдарч байгаа гадаад улсын иргэдийг хамруулаагүй болно.

Арав, түүнээс дээш настай хүн амд боловсролтой хүн амын дийлэнх буюу 28.5 хувь нь бүрэн дунд боловсролтой, 23.0 хувь нь дээд боловсролтой байна. Дээд боловсролтой хүн амын эзлэх хувь өмнөх тооллогынхоос 7.2 пунктээр өссөн байна.


## 7. ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 4979 өрх тоологдсон нь 2010 оныхоос 1138 буюу 29.6 хувиар өссөний дотор хотын өрх 4.1 хувь, хөдөөгийн өрх 101.5 хувиар өссөн байна.

Нийт өрхийн 16.7 хувь нь ганц бие, 63.7 хувь нь ам бүлээрээ байгаа, 19.1 хувь нь нийлмэл, 0.5 хувь нь холимог ам бүлтэй өрх байна.

Нийт өрхийн 3634 буюу 73.0 хувь нь Сүмбэр суманд, 338 буюу 6.8 хувь нь Баянтал суманд, 1007 буюу 20.2 хувь нь Шивээговь суманд тоологдсон байна.

ЗУРАГ 7. ӨРХИЙН ТОО, ӨРХИЙН ХЭЛБЭРЭЭР, 2020 ОН



Манай аймгийн ам бүлийн дундаж тоо 3.5 болсон нь 2010 оныхоос 0.2 пунктээр өссөн байна.

1-2 ам бүлтэй өрх 1667, 3-4 ам бүлтэй өрх 1868, 5-6 ам бүлтэй 1199, 7 –оос дээш ам бүлтэй өрх 245 байна. Нийт өрхөд 1-2 ам бүлтэй өрх 33.5 хувь, 3-4 ам бүлтэй өрх 37.5 хувь, 5-6 ам бүлтэй өрх 24.1 хувь, 7–оос дээш ам бүлтэй өрх 4.9 хувийг тус тус эзэлж байна.

2010 онтой харьцуулахад 1-2 ам бүлтэй өрх 0.3 пункт, 3-4 ам бүлтэй өрх 8.4 пунктээр буурч, харин 5-6 ам бүлтэй 7.0 пункт, 7–оос дээш ам бүлтэй өрх 1.7 пунктээр тус тус өссөн байна.


Хүн амын гэрлэлтийн байдалд огт гэрлээгүй хүмүүс өмнөх тооллогоос 4.3 пункт, цуцалсан хүмүүс 0.1 пунктээр өсч, харин гэр бүлтэй хүмүүс 3.7 пункт, бэлэвсэн хүмүүс 0.7 пунктээр тус тус буурлаа.

## 8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ


Говьсүмбэр аймгийн хэмжээнд 707 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 4.0 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 404 буюу 55.4 хувь нь эрэгтэй, 303 буюу 44.6 хувь нь эмэгтэйчүүд байна.



ЗУРАГ 8. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, ХЭЛБЭРЭЭР, 2010, 2020 ОН



ЗУРАГ 9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, СУМДААР, 2010, 2020 ОН



Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд өмнөх тооллогоос 84 буюу 45.6 хувиар өссөн нь сүүлийн 10 жилд хөрсний бохирдол, хүнсний шаардлага хангасан органик бүтээгдэхүүн хэрэглэж чадахгүй болон бусад хүчин зүйлийн нөлөөгөөр эхээс төрөхдөө л хөгжлийн бэрхшээлтэй байна гэсэн үг юм.

Харин олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өмнөх тооллогоос 113 буюу 34.7 хувиар өссөн нь аж ахуй нэгжийн аюулгүй ажиллагаа болон үйлдвэрийн осол гэмтэл, хүнд нөхцөлийн аюулгүй ажиллагаа, зам тээврийн осол нэмэгдсэнтэй холбоотой.

Төрөлхийн бэрхшээл их байгаа шалтгааныг удамшлын эмгэг, эх барихын болон төрөх үеийн хүндрэл, хорт нөлөө, хоол хүнсний аюулгүй байдал, хөрс, усны бохирдол зэрэг олон талаас нь нарийвчлан судлах шаардлага байна гэж харж байна.


Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл хөдөлгөөний бэрхшээл 2010 оны тооллогоос 8.7 хувь, харааны бэрхшээл 17.1 хувь, сонсголын бэрхшээл 32.3 хувь, сэтгэцийн бэрхшээл 4.3 хувиар өссөн байна.

Нийт бэрхшээлийн дийлэнх буюу 22.9 хувийг бусад хөдөлгөөний бэрхшээл эзэлж байгаа бол хамгийн бага буюу 2.1 хувийг ярианы бэрхшээл эзэлж байна.

## Үйлдлийн чадвар

Насны бүлгээр авч үзэхэд 45-аас дээш насныханд харааны, хөдөлгөөний, харин 55 түүнээс насныхны хувьд алхах, өөртөө анхаарал тавих хүндрэлүүд байгаа нь нас ахих тусам эдгээр хүндрэл зонхилж байгааг харж болохоор байна.

ЗУРАГ 10. ҮЙЛДЛИЙН ЧАДВАР, ХҮЙСЭЭР, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2020 ОН




## ИНТЕРНЭТ, ГАР УТАСНЫ ХЭРЭГЛЭЭ


Хүн ам, орон сууцны 2020 оны улсын тооллогоор Говьсүмбэр аймгийн 6, түүнээс дээш насны хүн амын 87.1 хувь нь гар утас, 63.0 хувь нь интернэт хэрэглэж байна.

Зургаа, түүнээс дээш насны хүн амын гар утас хэрэглэгчид 2010 оны дүнд эзлэх хувиас 11.1 хувиар, интернэт хэрэглэгчид 38.6 хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 11. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН ГАР УТАС ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН



ЗУРАГ 12. ЗУРГАА, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСТАЙ ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, ИНТЕРНЭТИЙН ХЭРЭГЛЭЭ, 2020 ОН



### 9. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ

Хөдөлмөрийн насны буюу арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 6952 буюу 60.8 хувь нь ажиллах хүчинд багтаж байгаа нь 2010 оноос 1.9 пунктээр буурсан бол ажиллах хүчнээс гадуурх хүн ам (39.2%) 1.4 пунктээр өссөн байна.


Нийт хөдөлмөрийн насны хүн амд ажил эрхэлдэг хүн амын эзлэх хувь өнгөрсөн тооллогын үеийнхээс 3.9 пунктээр, ажиллах хүчнээс гадуурх хүн амын хувийн жин 8.6 пунктээр тус тус буурч, ажилгүй иргэд 4.7 хувийг эзэлж байна. 55 наснаас эхлэн цаашид нас ахих тутам хүмүүсийн хөдөлмөрийн чадвар буурч, 60, түүнээс дээш насны хүн амын 2.2 хувь ажиллах хүчинд хамрагдаж байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс тухайн насны хүн амын ажиллах хүчинд эзлэх хувь 1.8 пунктээр буурсан үзүүлэлттэй гарлаа.

ЗУРАГ 13. АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ТАЛААРХ БҮДҮҮВЧ, 2020 ОН




Эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, эмэгтэйчүүдийнхээс өндөр хэвээр байна. Байршлын хувьд эрэгтэй, эмэгтэйчүүдийн аль алиных нь ажиллах хүчний оролцоо хөдөөд аймгийн төвийнхөөс өндөр байна. Ялангуяа, хөдөөгийн эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо 57.0 хувь байгаа нь аймгийн төвийнхөөс 5.7 пунктээр илүү байна.

ЗУРАГ 14. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, СУМДААР



ЗУРАГ 145. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН ХОТ, ХӨДӨӨГӨӨР



Ажилгүй иргэдийн дотор 30-44 насны 267 залуучууд байгаа нь хамгийн их буюу нийт ажилгүй хүний 49.3 хувийг эзэлж байна. Харин 30-аас дээш насныханд эрэгтэйчүүд илүү их ажилгүйдэлд өртөж байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд ажиллах хүчнээс гадуурх хүн ам нийтдээ 4.5 мянга байгаа нь өмнөх тооллогоос 32.4 хувиар, үүний дотор ажиллах сонирхолгүй хүний тоо 53.3 хувиар, сургуульд сурдаг 37.2 хувиар, тэтгэвэрт 37.2 хувиар, тохирох ажил олдохгүй байгаа 23.2 хувиар тус тус өсжээ. Харин хөдөлмөр эрхлэх чадваргүй 24.2 хувиар, гэрийн ажилтай 23.7 хувиар тус тус буурсан байна.

## 10. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭД

ЗУРАГ 15. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХҮН АМЫН ТОО




Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын дүнгээр Говьсүмбэр аймгийн 512 иргэн гадаадад тоологдсон байна. Үүнээс 32.6 хувь нь хувиараа ажиллах, 22.8 хувь нь суралцах, 10.2 хувь нь гэр бүлийн шалтгаанаар оршин суух, 7.0 хувь нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллах, 5.5 хувь нь суурьших, 0.4 хувь нь албан томилолтоор, 21.5 хувь нь бусад шалтгаанаар гадаадад байна.

Говьсүмбэр аймгаас гадаадад тоологдсон иргэдийн 72.4 хувь нь Ази, Номхон далайн бүс нутагт, 22.1 хувь нь Европ тивд, 5.5 хувь нь Америк тивд суугаагаар тоологдсон байна.


Манай аймгийн гадаадад оршин суугаа иргэдийн тоо 2010 оны дүнтэй харьцуулахад 3.2 дахин нэмэгдсэн байна.

ЗУРАГ 16. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭД, БАЙНГА ОРШИН СУУЖ БАЙСАН СУМААР, 2020 ОН



Гадаадад оршин суугаа иргэдийг байнга оршин сууж байсан сумаар нь авч үзвэл 408 буюу 79.7 хувь нь Сүмбэр сумын иргэн, 85 буюу 16.6 хувь нь Шивээговь сумын иргэн, 19 буюу 3.7 хувь нь Баянтал сумын иргэн байна.

ЗУРАГ 17. ГАДААДАД ОРШИН СУУГАА ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ИРГЭД, ТООЛЛОГЫН ҮЕД СУУЖ БАЙГАА ЗОРИЛГО, ХУВИАР, 2020 ОН



### 11. СУУЦНЫ НӨХЦӨЛ

Говьсүмбэр аймгийн 4979 өрх 4549 сууцанд амьдарч байна. Эдгээрээс нийтийн зориулалттай орон сууц 58, бие даасан сууц 710, бие даасан тохилог сууц 26 байна.

Нийт өрхийн 3021 буюу 60.7 хувь нь байшин, орон сууцанд 38.0 хувь нь гэр сууцанд, бусад сууцанд 1.3 хувь нь амьдарч байна.

Аймгийн хэмжээнд нийтийн зориулалттай орон сууц 58 байгаагийн 39 буюу 67.3 хувь нь Сүмбэр суманд, 14 буюу 24.1 хувь нь Шивээговь суманд, 5 буюу 8.6 хувь нь Баянтал суманд байршиж байна. Манай аймгийн хувьд нийтийн зориулалттай орон сууцанд амьдарч буй өрхийн тоо 2088 буюу нийт өрхийн 42.0 хувь байна.

### ХҮСНЭГТ 2. ГЭР, БАЙШИН, ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРӨЛ, ХОТ, ХӨДӨӨГӨӨР, 2020 ОН

	Хүн байнга амьдардаг сууц				Өрхийн тоо			
	Бүгд	Сүмбэр сум	Шивээговь сум	Баянтал сум	Бүгд	Сүмбэр сум	Шивээговь сум	Баянтал сум
БҮГД	4 549	3 146	994	409	4 979	3 634	1 007	338
Гэр	1 370	1 087	168	115	1 863	1 505	213	145
Байшин	3 179	2 059	826	294	3 021	2 067	789	165
Бусад сууц	-	-	-	-	95	62	5	28


\*Орон сууцны байшингийн доторх сууцыг нэмж оруулав.

Нийт өрхийн 37.4 хувь нь Монголын ард түмний уламжлалт сууц болох гэрт, 60.7 хувь нь байшинд, 1.9 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь өмнөх тооллогын үеийнхээс 1.7 пунктээр өсч, байшинд амьдардаг өрхийнх 2.1 пунктээр буурсан. Энэ нь хөдөөгийн хүн ам нэмэгдэж байгаатай холбоотой.

ЗУРАГ 18. ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, 2020 ОН



ЗУРАГ 19. ХҮН АМЬДРАН СУУХ ЗОРИУЛАЛТТАЙ НИЙТ СУУЦ БОЛОН ХҮН БАЙНГА АМЬДАРДАГ СУУЦНЫ ТОО, ТӨРЛӨӨР, 2020 ОН



Тооллогоор хүн байнга амьдардаг сууцнаас сууцны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг амьдарч буй өрхөөс асууж цуглуулсан.

Нийтийн зориулалттай 58 орон сууцны байшинд 2 439 сууц тоологдсон байна.